ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр Дугаар А/79 Мөрөн

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх "Тэр бум мод үндэсний хөдөлгөөн, Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын батлагдсан төсвөөс холбогдох хууль журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6712070133

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 16-ны өдрийн
А/ 79 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

“ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, МОД ТАРЬЖ НОГООН СУВАРГА БОСГОЁ АЯНЫ” ХҮРЭЭНД МӨРӨН СУМЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ

Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Санхүүжих дүн /сая төгрөг/
			2023 он
“Тэр бум мод үндэсний хөдөлгөөн, Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил	“Мөрөн сумын 2 дугаар баг 7 дугаар цэцэрлэгийн урдаас 2 дугаар багийн хатуу хучилттай авто замын уулзвар хүртэл ногоон зурвас байгуулах /Ногоон зурвас-3/	200,0	200,0
	Мөрөн сумын 8 дугаар баг Хөдөлмөр халамж үйлчилгээний төвийн урд голын эрэг дагуу тохижилтын зарим хэсэг /Тохижилт -2/	100,0	100,0
Нийт дүн		300,0	300,0

_____oOo_____